

## ТЭРГҮҮН

**МИЛИТАРИСТ ЯПОНЫГ БУТ ЦОХИСНЫ ТҮҮХЭН  
АЧ ХОЛБОГДОЛ, ОРЧИН ҮЕ**

**С.Ишдорж** (түүхийн ухааны дэд эрдэмтэн,  
**Л.Бэгзжав**

Он жилүүд улиран өнгөрөх тутам одоогоос 40 жилийн өмнө дэлхийн 2-р дайн дуусч, түүнд эрх чөлөөг эрхэмлэгч улс түмэн, нэн түрүүн Зөвлөлтийн ард түмэн, түүний зэвсэгт хүчин ялалт байгуулсны дэлхий дахины түүхэн ач холбогдол улам их болж байна. Энэ ялалтын 40 жилийн ойг Монголын ард түмэн ЗХУ ба социалист бусад орны ард түмний болон нийт дэвшилт хүн төрөлхтөний хамт ёслол төгөлдөр тэмдэглэв.

Одоогоор 40 жилийн өмнө дууссан дэлхийн 2-р дайн нь хүн төрөлхтөний түүхэнд болсон хамгийн ширүүн, хамгийн том дайн байлаа. Энэ дайн бүтэн 6 жил үргэлжилж, дэлхийн 61 улс орныг хамарсан юм. Энэ дайныг бэлтгэгчид нь олон улсын империалист харгис хүчин байсан бөгөөд тэд энэ дайнаар социализмыг устгах, ингэснээр дэлхийн хувьсгалт хөдөлгөөнийг дарах зорилго тавьж байжээ. АНУ, Англи, Франц болон бусад орны империалист харгис хүчний зүйл бүрийн дэмжлэгийг олж байсан фашистын Герман, Итали, Японы дайнчид нь дэлхийн 2-р дайныг гол дайныг гол дэгдээн явуулагчид байв. Гэвч фашистын түрэмгийлэгч эдгээр улс эрх баригчдын хомхойрол нь зөвхөн социализмыг устгаж, олон улсын хувьсгалт хөдөлгөөнийг дарахад чиглээд зогсоогүй, харин тэд дэлхий дахиныг хуваан ноёрхохыг эрмэлзэхдээ өөрсдийг нь тэтгэн дэмжиж байсан АНУ, Англи, Франц зэрэг империалист өрсөлдөгчидтэйгөө ашиг сонирхол нь зүй ёсоор мөргөлджээ. Ийм ч учраас дэлхийн 2-р дайн нь нэн түрүүн нэг талаас фашистын түрэмгийлэгч Герман, Итали, Япон улсууд, нөгөө талаас империалист гүрэн Англи, франц зэрэг орны хооронд эхэлжээ.

АНУ, Английн эрх баригчид ч бас дэлхий дахиныг ноёрхох зорилгодоо хүрэхийн тулд фашистын түрэмгийлэгч улсуудыг ЗХУ-тай мөргөлдүүлж, тэдний хүчийг сулруулан дундаас нь хожихыг оролдож, 2-р фронт нээх асуудлыг даруй 2 жил гаруй хугацаагаар хойшлуулж байлаа.

1941-1945 онд зөвлөлтийн ард түмнээс фашистын Герман, милитарист Японы эсрэг явуулсан Эх орны аугаа их дайн нь дэлхийн 2-р дайны шинж байдлыг үндсээр нь өөрчилж, империалист дайныг фашистын түрэмгийлэлд нэрвэгдсэн улс түмний чөлөөлөх шударга дайн болгон хувиргажээ.

Милитарист Япон улс нь 30-аад оны эхнээс дэлхийн 2-р дайны анхны голомтыг үүсгэн, уг дайныг дэгдээн явуулагч гол орнуудын нэг

байлаа. Японы милитаристуудын эзлэн түрэмгийлэх төлөвлөгөө 1927 онд тэр үед Японы Ерөнхий сайд байсан Гиити Танакаас Японы эзэн хаанд илгээсэн меморандум (санамж бичиг)-д тодорхой тусгагдсаны дотор Япон улс “Оростой дахин илд харшилдуулах нь зүйтэй”<sup>1</sup> гэж дурджээ. Тэгээд цааш нь уг санамж бичигт: “Бид бүх дэлхийг байлдан эзлэхийн тулд эхлээд Хятадыг байлдан дагуулах ёстой, Хятадыг авахын тулд Манжуур, Монголыг байлдан эзлэх хэрэгтэй...”<sup>2</sup> гэх мэтчилэнгээр Азийн үлдсэн бусад орон, түүгээр ч үл барам Европыг байлдан дагуулах дайнд шилжин орох тухай дурдсан байдаг билээ.

Японы монопольт капиталын ашиг тусын тулд Японы дайнч бүлгийнхэн цэрэг дайны дээрх түрэмгий төлөвлөгөө зөвхөн тунхаглаад зогсоогүй түүнийгээ хэрэгжүүлэх фашистын Герман, Италитай Япон Улс “Коминтерний эсрэг гэрээ” гэгчийг байгуулан, улмаар 1940 онд Герман, Итали, Японы хооронд цэргийн холбоо болгон гурвалсан гэрээ” хэмээх баримт бичигт гарын үсэг зуржээ. Энэ гэрээгээр Гитлерийн Герман гал мэсийн хүчээр Европт “шинэ журам”-ыг тулган тогтоож байхад Японы дайнчид Азийг “цагаан арьст колончлогчдоос чөлөөлөх” гэдэг хуурамч уриан дор өөрийн харьяанд байх “Азийн мандал бадралын аугаа их хүрээ” гэгчийг мөн гал мэсийн хүчээр тулган хүлээлгэхээр тогтжээ.<sup>3</sup>

Японы дайнчид дээрх түрэмгий төлөвлөгөөнийхөө дагуу 1931 онд Манжуурыг эзлэн авч, тэнд “Манж-го” хэмээх тоглоомын усыг байгуулж, манай улс болон ЗХУ-ын аюулгүй байдалд шууд заналхийлэн, жижиг зэвсэгт өдөөн хатгалгаас эхлэн зарлаагүй үлэмж хэмжээний цус урсгасан дайн явуулах хүртэл адал балмад ажиллагааг үйлдэж байв. Японы дайнчид 1937 оны 7-р сард Хятадын ард түмний эсрэг том дайн эхэлснээс гадна 1938 онд ЗХУ руу Хасан нуурын районоор, 1939 онд БНМАУ руу Халх голын районоор довтолж зөвлөлт, Монголын цэрэгт бут цохигдож байлаа.

1942 онд дунд үе гэхэд Япон улс нь 400 сая шахам хүн ам аж төрсөн 9 сая 801 мянган хавтгай дөрвөлжин километр бүхий газар нутгийг эзлэн авч өөрийнхөө эрхшээлд оруулсан байв. Түүний байлдан эзэлсэн газар нутагт Малай, сингапур, Индонезийн гол арлууд, Бирм, Филиппин, Гуам, Шинэ Бретана арлууд, Соломны арлууд орж байлаа. Японы дайнчдын эзэлсэн эдгээр газар нутаг нь Японы өөрийн нь газар нутгаас бараг 32 дахин их байв. (1940 оны байдлаар километр байв). Түүгээр ч үл барам Японы дайнчдын шунахай санаархал нь бүр цагаандаа гарч гааран, тэд “Азийн мандал бадралын аугаа их хүрээ” гэгчдээ ЗХУ-ын Камчатка, тэнгис орчмын нутаг баруун, зүүн Сибирь, Зөвлөлтийн Дундад Азийн бүгд найрамдах улсуудын зарим хэсэг, БНМАУ-ын Афганистан, Ираны нутаг дэвсгэрийн зарим хэсэг, Балба, Энэтхэг, Австрали, Шинэ Зеланд, Гавайн арлуудыг нэгтгэхээр санаархаж байжээ.<sup>4</sup>

Японы эрх баригчид хэдийгээр 1941 оны 4-р сарын 13-нд ЗХУ-тай “төвийг сахих” тухай гэрээг 5 жилийн хугацаагаар байгуулсан боловч Германы Фашизмын эсрэг ЗХУ-ын Эх орны аугаа их дайны жилүүдэд Зөвлөлт, Монголын хилийн дагуу цэрэг зэвсгийн хүчээ эрс нэ-

---

<sup>1</sup> Энэ меморандум бүрэн эхээрээ “Нийгэм журмын зам” сэтгүүлд бий. УБ., 1932 № 1-2(43-44), 90-124-р тал

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Леонид Внодченко. Алс Дорнодод хийсэн ялалт. М., 1981, АПН, 8-р тал /монгол хэл дээр/

<sup>4</sup> Мөн тэнд

мэгдүүлж (Манжуурт байрлаж байсан Квантуны армийн цэргийн тоог 1941 онд 300 мянга байсныг 1942 оны 1 сая 100 мянга болгосон), 1941-1943 онд зөвлөлтийн тэнгис орчмын нутагт 500 гаруй удаа зэвсэгт өдөөн хатгалга үйлдэж, зөвлөлтийн худалдааны хөлөг онгоцуудыг саатуулан барьж, заримыг нь живүүлж ч байжээ.<sup>5</sup> Энэ бүхэн нь ЗХУ-ыг Зөвлөлт-Германы фронтод зайлшгүй шаардлагатай байсан 40 шахам дивизийг Алс Дорнодынхоо хил дээр байнга барьж байхад хүргэжээ.

Ийнхүү зөвлөлт Японы “төвийг сахих” тухай гэрээг Япон улс биелүүлэхгүй зөвхөн цаас мэт түүнд хандаж байна. Үүнийг уг гэрээнд гарын үсэг зурсан Японы Гадаад явдлын яамны сайд агсан Мацуока Москвагаас Япондоо буцаж очоод Токиод сууж байсан Германы Элчин сайд Эйген Оттотой уулзаж ярилцахдаа: “Герман, ЗСБНХУ-ын хооронд мөргөлдөөн гарах юм бол Японы ямар ч ерөнхий сайд буюу Гадаад явдлын Яамны сайд Япон улсыг төвийг сахисан байдалд байлгаж чадахгүй. Ийм нөхцөлд Япон Улс Орост халдан довтолход хүрэх нь мэдээж. Тэгэхэд хүрвэл төвийг сахих тухай ямар ч гэрээ биднийг зогсоохгүй”<sup>6</sup> гэж хэлсэн явдал нотолж байна. Ер нь фашистын Герман ЗХУ-д довтолмогц Япон улс нь Зөвлөлтийн эсрэг дайнд ороход шууд бэлтгэж эхлэн харин гагцхүү өөртөө зайлшгүй цаг мөчийг хүлээж байжээ. Гэвч Зөвлөлтийн арми Германы цэргийг Москва, Сталинград, Курскийн нуманд бутцохисон явдал Японы дайнчдын төлөвлөгөөг нураажээ.

1945 оны тавдугаар сард Германы фашизм бутцохигдон бууж өгсөн нөхцөл байдалд Японы милитаристууд Ази, Номхон далайн районд дэлхийн хоёрдугаар дайныг үргэлжлүүлэн, Хятад, Солонгос, Энэтхэг-Хятадын хойг, Азийн бусад олон орныг түрэмгийлэн эзэгнэсэн хэвээр байв. Тэд хуурай замын томоохон арми, цэрэг-аж үйлдвэрийг хүчирхэг потенциалтай байсан юм. 1945 оны наймдугаар сард Японы зэвсэгт хүчин 7 сая гаруй хүн, 10 мянга гаруй нисэх онгоц, 500 орчим байлдааны хөлөг онгоцтой байжээ.<sup>7</sup> Японы эрх баригчид “шийдвэрлэх тулалдаан”-д бэлтгэх, бүх нийтийн цэрэг дайчилгааг дахин явуулж, цэрэг-эдийн засаг, тээвэр, иргэний захиргаагаа өөрчлөн байгуулсан байв. АНУ, Английн эрх баригчид японыг бутцохиход ЗХУ-ыг оролцуулах гэж чармайж байлаа. Өрнөдийн эрх баригчид, цэргийн мэргэжилтнүүд Японы эсрэг дайнд ЗХУ оролцохгүй бол Ази, Номхон далай дахь дайн Германыг ялснаас хойш наад зах нь 18 сар үргэлжилнэ гэж үзэж байв.

Ийм нөхцөлд дэлхийн 2-р дайн дуусах явдал улам сунжирч, олон улс орны үлэмж тооны хүн амын амь насыг бүрэлгэн, эд материалын ихээхэн хохирол учруулах байлаа. Үүнийг АНУ, Английн засгийн газар үзэхдээ Номхон далайн дайныг түргэн дуусгах явц нь Азийн эх газарт байгаа Японы хуурай замын цэргийг буулгахад наад зах нь 5 сая шахам цэрэг хэрэгтэй болно гэж үзэж байсан ба иймээс Японы хуурай замын цэргийг бутцохиход ЗХУ-ыг оролцуулахгүй юм бол Номхон далайн дайн дахиад 1 жил хагасаас доошгүй хугацаа шаардаг-

---

<sup>5</sup> Мөн тэнд 21-р тал

<sup>6</sup> Мөн тэнд 20-р тал

<sup>7</sup> “Проблемы Дальнего Востока” сэтгүүл., М., 1985, № 2, 30-р тал

дана, тэгвэл АНУ-ын 1 саяас доошгүй цэргийн амь насыг бүрэлгэхэд хүрнэ гэж бодитойгоор хүлээн зөвшөөрч байжээ.<sup>8</sup>

Ингээд ч АНУ, Английн төлөөлөгчид бүр 1943 оны Тегераны бага хурал дээр ЗХУ-ыг Японы эсрэг дайнд оролцохыг хүсч байжээ. 1945 оны 2-р сард болсон ЗХУ, АНУ, Английн тэргүүн нарын Крым (Ялт)-ын бага хурал дээр ЗХУ Германыг бууж өгмөгц 2-3 сарын дараа дор дурдсан болзолтойгоор империалист Японы эсрэг дайнд орох болжээ. Үүнд:

1. Гадаад Монгол (Бүгд Найрамдах Монгол Ард Улс)-ын төрийн бүрэн эрх байдлыг хэвээр хадгалах;

2. 1904 онд Японы түрэмгийллийн улмаас алдагдсан Оросын эрхийг сэргээх (Өмнөд Сахалин, Порт-Артурын боомт);

3. Курилын арлуудыг ЗХУ-д эгүүлэн шилжүүлэх.<sup>9</sup>

Эдгээр болзлыг өрнөдийн гүрнүүд зөвшөөрсний үндсэн дээр ЗХУ милитарист Японы эсрэг дайнд орох болсон нь дэлхийн хоёрдугаар дайны сүүлчийн голомтыг аль болох түргэн дарж, бүх нийтийн энх тайвныг сэргээхэд тус дөхөм үзүүлэх, холбоотныхоо хамт Японы түрэмгийлэгчдийг эзлэн авсан нутаг орноос хөөн зайлуулах, Зөвлөлтийн Алс Дорнод болон БНМАУ-ын хил орчим дахь Японы байнгын аюул заналыг арилгахад чиглэж байлаа.

1945 оны долдугаар сард Потсдамд АНУ, Англи, Хятадын нэрийн өмнөөс Японыг үг дуугүй бууж өгөхийг шаардсан Тунхаглал гаргасан юм. Гэвч Японы Засгийн газар өөртөө байгаа их хүчинд найдаж, цаашид байлдааныг үргэлжлүүлэх боломжтой гэж үзэн, үг дуугүй бууж өгөхөөс татгалзжээ.

ЗХУ холбоотны өмнө авсан үүргээ үнэнчээр биелүүлэн Германы фашизмыг ялснаас хойш яг 3 сарын дараа милитарист Японы эсрэг шударга дайнд орлоо. 1945 оны наймдугаар сарын 8-нд Японд дайн зарласан тухай Зөвлөлт Засгийн газрын мэдэгдэл гарчээ. Уг мэдэгдэлд ЗСБНХУ 1945 оны долдугаар сарын 21-ний өдрийн Потсдамын Тунхаглалд нэгдэн Японы эсрэг дайнд оролцоно уу гэсэн холбоотой гүрнүүдийн саналыг хүлээн авч байгааг дурдаад, “Зөвлөлт засгийн газрын энэ бодлого бол энх тайвныг тогтоох хугацааг ойртуулах, улс түмнийг цаашдын гамшиг зовлонгоос гэтэлгэн, үг дуугүй бууж өгөхийг татгалзсанаасаа болж Германы амссан шиг тийм аюул сүйрлээс Японы ард түмнийг ангижруулах боломж олгох цорын ганц хэрэглүүр мөн”<sup>10</sup> гэж тэмдэглэсэн байна. ЗХУ наймдугаар сарын 9-нөөс Японтой дайны байдалтай болсныгоо зарлажээ.

Империалист Японы эсрэг дайнд ЗХУ орсон нь Эх орны аугаа их дайны зүй ёсны үргэлжлэл, фашизм, милитаризмын эсрэг зөвлөлтийн ард түмний баатарлаг тэмцлийн салшгүй хэсэг байлаа.

Фашист эвслийн гол холбоотон милитарист Японы эсрэг дайнд ЗХУ оролцохоор Крымын бага хурал дээр үүрэг авахдаа БНМАУ-ын тусгаар тогтнолыг АНУ, Английн эрх баригчдаар хүлээн зөвшөөрүүлэхийг анхдагч болзол болгон тавьсан нь БНМАУ-ын бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг бэхжүүлэх, олон улсын нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн интернационалч бодлогын илрэл байв. Зөвлөлт засгийн газрын энэ шийдвэрийг энх тайвныг эрхэмлэгч шударга улс түмэн,

<sup>8</sup> Леонид Винотченко. Алс Дорнодод хийсэн ялалт. М., 1981 (монгол хэлээр)

<sup>9</sup> “Великая Отечественная война Советского Союза. 1941-1945. (Краткая вектория). изд.второе. М., 1970, 538-р тал

<sup>10</sup> Внешняя политика Советского Союза в период Великой отечественной войны. М., 1947 боть 3, 362-363-р тал

Японы түрэмгийлэлд өртсөн Азийн олон улс орон, ард түмэн, түүний дотор Монголын ард түмэн халуунаар сайшаан дэмжлээ.

БНМАУ-ын Бага Хурал, Засгийн газар ард түмнийхээ хүсэл санааг илэрхийлэн Японы милитаристууд БНМАУ-ын эсрэг нэг биш удаа түрэмгийлэл үйлдэж байсныг харгалзан 1945 оны наймдугаар сарын 10-нд гаргасан Тунхаглалдаа: “Эдүгээ Монгол Ардын Улсын Бага Хурал ба Засгийн газар болбаас... 1936 оны гуравдугаар сарын 12-ны өдөр нийслэл Улаанбаатар хотноо байгуулсан СССР, Бүгд Найрамдах Монгол Ард Улс хоёрын харилцан туслалцах гэрээ доторх үүргээ үнэнчээр биелүүлэн, мөн түүнчлэн нийтийн дайсныг түргэнээр бүрмөсөн цохиж устгах хэмээсэн ардчилсан улсууд ба эрх чөлөөг эрмэлзэгч дэлхийн ард түмний нэгэн санаа зорилгоор бахархан зоригжиж, Нэгд Үндэстний үйлсэд өөрийн тус нэмрийг оруулахын тулд нэгдсэн Үндэстний талд оролцон Япон улстай байлдах ариун дайныг эрхэмсгээр зарлан, энэ оны наймдугаар сарын 8-ны өдөр Москва хотод Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газраас зарлан тунхагласан лугаа манай санал нь яв цав нийлэв”<sup>11</sup> гэж ёслол төгөлдөр мэдэгдсэн байна.

БНМАУ милитарист Японд дайн зарласан нь эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон төр улсаа батлан хамгаалах, Монгол-Зөвлөлтийн ах дүүгийн эвдэршгүй найрамдлаа бэхжүүлэн бататгахыг үндэс болгосон зүй ёсны шударга хэрэг байлаа.

Зөвлөлтийн арми, Монгол Ардын Хувьсгалт цэрэг милитарист Японыг бутниргэх шударга дайнд мөр зэрэгцэн байлдсан юм.

Зөвлөлтийн арми алс Дорнодын нэгдүгээр Фронт, хоёрдугаар фронт, Өвөр Байгалийн фронтын 3 чиглэлээр давшин, Зүүн хойд Хятад, Умард Солонгосыг чөлөөлөн, Манжуур Солонгос дахь Японы цэрэг-стратеги, эдийн засгийн гол баазуудыг эзлэн авч, ЗХУ, БНМАУ-ын эсрэг халдан довтолоход бараг 15 жил сайтар бэлтгэсэн Японы хуурай замын гол хүч-Квантуны шигшмэл армийг ердөө 23-хан хоногийн дотор бутцохисон юм. Японы империалистууд оршин тогтносон түүхэндээ ийм том ялагдал хэзээ ч хүлээж байгаагүй ажээ. Зөвлөлт, Монголын ах дүү арми Японы цэрэгт эзлэгдээд байсан Зүүн Хойд Хятад, Өвөр Монголын нутгаар богино хугацаанд шуурхай давшиж, байгаль цаг уурын хэцүү нөхцөл болон цахарын усгүй элсэн цөл, Их Хянганы бартаат уулс, Зүүн Хойд Хятадын туулшгүй түргэн урсгалт өргөн гол мөрөн, намаг шавар, аадар бороог гэтлэн давж Японы олон бэхлэлт, хамгаалалтыг сэт цохин, Квантуны армийн гол хүч, Манж-Гогийн арми, Өвөр Монголын Дэ вангийн (Дэмчигдонровын) цэрэг, Суйюаний армийн бүлэглэл зэрэг нийт 10 арми, цэргийн бүлэглэл, нэг усан флотын хүчийг бутцохижээ.<sup>12</sup>

Нийтийн дайсан милитарист Японы эсрэг Зөвлөлт, Монголын арми хамтран тэмцсэн нь тус хоёр орны найрамдалт харилцааг улам бэхжүүлж, Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн бат барилдалгааны дайчин бэлэг тэмдэг болсон юм.

Дэлхийн хоёрдугаар дайны сүүлчийн шатанд БНМАУ Зөвлөлтийн армийн хамт дайн, милитаризмын эсрэг тэмцэлд идэвхтэй оролцон, даян дэлхийн энх тайван, улс түмний аюулгүй байдлын төлөө тэмцсэний үрээ БНМАУ-ын тусгаар тогтнол батжин бэхжиж энх цагийн бүтээн байгуулалтын таатай нөхцөл бүрэлдсэнээр манай улсын олон улсын нэр хүнд эрс өслөө.

<sup>11</sup> “Үнэн” 1945, VIII, 10.

<sup>12</sup> “Великая Отечественная война Советского Союза 1941-1945 гг”. (краткая история). М., 1970. 553-р тал

Зөвлөлт, Монголын дайчдын амжилттай давшилтын үрээр ХКН-ын удирдлагад байсан хувьсгалт цэргүүд Японы эсрэг довтолгоонд мөн орох бололцоотой болжээ. Үнэндээ Хятадын 8-р армийн ангиудыг байлдаж эхлэхээс өмнө Зөвлөлт-Монголын дайчдын эрчимтэй шуурхай давшилт нь Японы эргийн гол хүчийг аль хэдийнээ бутцохисон байлаа. Зөвлөлт, Монголын арми Зүүн Хойд Хятад, Өвөр Монголыг чөлөөлснөөр Хятадын ард түмнээс гоминьданы дэглэмийн эсрэг хувьсгалт тэмцэл өрнүүлэхийн аятай таатай нөхцөлийг бүрэлдүүлсэн юм.

1945 оны есдүгээр сарын 2-нд Токиогийн буланд Америкийн цэргийн “Миссури” хөлөг онгоцонд Японы милитаристууд үг дуугүй бууж өгөх тухай актад гарын үсэг зуржээ. Фашист эвслийн нэг гол улс милитарист Япон ийнхүү ялагдсанаа хүлээн зөвшөөрснөөр хүн төрөлхтөний түүхэнд хамгийн их цус урсгасан, хатуу ширүүн дэлхийн хоёрдугаар дайн дууссан байна.

Милитарист Японы бутцохисон ялалт нь Азийн улс төрийн байдалд үндсэн өөрчлөлт бий болоход хүргэж, Хятад, Умард Солонгос, Вьетнамд ардын хувьсгал ялах тааламжтай нөхцөл бий болгон Индонез, Бирм, Камбож (Кампучи), Лаос, Малай, Энэтхэг, Филиппин болон Азийн бусад оронд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн далайцтай өрнөхөд эрчимтэй нөлөө үзүүлэв.

Гитлерийн Герман, милитарист Японыг бут цохисон нь дэлхий дахины түүхэн ач холбогдол бүхий аугаа их ялалт байв. Энэ ялалт нь хүн төрөлхтөний хөгжил дэвшлийн үйл явцад гүн гүнзгий нөлөөлсөн олон улсын түүхэн ач холбогдол бүхий үйл явдал болсон юм. Энэ утгаараа дэлхий хоёрдугаар дайнд социализм, ардчилал, энх тайвны хүчний байгуулсан ялалт нь ХХ зууны агуу их үйл явдал байлаа. Энэ бол Октябрийн социалист их хувьсгалаар үүсч бий болсон социалист ертөнцийн түүхэнд чөлөөлөгч их ялалт байв. Энэ ялалт нь марксизм-ленинизмийн үзэл санааны ялалт, социализмын хувьсгалжуулагч нөлөөний үр дүн байлаа. Социализм ЗХУ, БНМАУ-ын хүрээнээс халин гарч дэлхийн дахины систем болж бүрэлдэн тогтсон нь Октябрийн хувьсгал эхлэлтийг нь тавьсан хүн төрөлхтөн капитализмаас социализмд шилжих дэлхий дахины түүхэн үйл явдлын шууд үргэлжлэл боллоо. Олон улсын хүчний харьцаа социализмын талд ашигтайгаар өөрчлөгдөж, дэлхийн социалист систем, түүний нягтармал гол цөм-социалист хамтын нөхөрлөл нь орчин үеийн дэлхий дахины амьдралд хамгийн эрүүл саруулаар нөлөөлөгч гол хүч болж, дэлхийн хувьсгалт үйл явцыг урьд өмнө үзэгдээгүйгээр гүнзгийрүүлж байна.

Дэлхийн хоёрдугаар дайнд социализм, ардчилал, энх тайвны хүч ялсан нь олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хэзээ хэзээнээс илүү өрнүүлж, түүхэн шинэ шатанд оруулав. Хэрэв 1939 онд дэлхийн 61 улс оронд коммунист ажилчны нам ажиллаж, эгнээндээ 4 сая коммунистыг хамарч байсан бол одоо дэлхийн 95 улс оронд коммунист ажилчны нам ажиллаж, тэдгээрийн эгнээнд 80 сая гаруй коммунистууд хамрагдаж байна.<sup>13</sup> Ийнхүү олон улсын коммунист хөдөлгөөн нь империализм, харгислал, дайны эсрэг, социализм, ардчилал, үндэсний эрх чөлөө, энх тайвны төлөө ажилчин анги, хөдөлмөрчид, өргөн олон түмний тэмцлийг манлайлсан орчин үеийн хамгийн нөлөө бүхий улс төрийн хүч боллоо.

---

<sup>13</sup> “Энх тайван, социализмын асуудал”, 1985, № 5, 9-р тал

Дэлхийн 2-р дайнаас хойш өнөөг хүртэл Ази, Африк Латин Америкийн 100 гаруй улс орон тусгаар тогтнолоо олж, империализмын колонийн систем задран уналаа. Энэ нь дэлхий дахины улс төрийн амьдралд чанарын их өөрчлөлт оруулж, дэлхийн социализмын хүч нөлөөг нэмэгдүүлэн, олон улсын империализм, харгислал, дайны хүчинд том цохилт болж байна.

40 жилийн өмнөх ялалтын түүхэн ач холбогдлын нэг нь нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших, хэлэлцээний замаар хамтран ажиллахын зайлшгүй бөгөөд боломжтой болох тухай В.И.Лениний сургаалын үнэн мөнийг амьдралд харуулж байгаа явдал юм. Империалист харгис хүчний буруугаар олон улсын байдал ноцтойгоор хурцадсан өнөө үед өнгөрсөн дайны үеийн энэ түүхэн туршлага онцгой чухал ач холбогдолтой болж байна.

Германы фашизм, Японы милитаризмыг ялсны 40 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолд дэлхийн хоёрдугаар дайны “хамгийн гол сургамж нь дайн гарахаас урьдаж энх тайвны төлөө тэмцэх хэрэгтэй гэдэгт оршино” гэж тэмдэглэжээ.<sup>14</sup>

Өнөө үед олон улсын империалист харгис хүчин, юуны өмнө АНУ-ын Рейганы засаг захиргаа цэрэг зэвсгийн хойноос улайран хөөцөлдөж, Дорнод, Өрнөдийн хоорондын цэргийн хүчний тэнцвэрийг алдагдуулан, хүчний хувьд давуу байдалтай болж авахыг оролдож байна. Түүгээр ч үл барам түүхэн сургамжийг үл хайхран, тэд хүн төрөлхтөнийг нэгмөсөн сөнөөх пуужин-цөмийн дайны ангал руу аваачихыг эрмэлзэж байна. Энэ адал балмад зорилгод Рейганы засаг захиргааны “Оддын дайны” программ чиглэж байна. Энэ программд Японыг татан оролцуулах талаар хийж байгаа оролдлого нь ихээхэн аюултай алхам мөн.

Япон улсын өнөөгийн эрх баригчид дэлхийн 2-р дайны түүхэн сургамжийг үл хайхран Ази, Номхон далайн районд Америкийн империализмын цэрэг-улс төрийн стратегид захирагдаж өөрийн орныг улс түмний энх тайван, аюулгүй байдалд заналхийлсэн хүч болгон хувиргаж байна.

1946 онд баталж, 1947 оны 5-р сарын 3-наас хүчин төгөлдөр болсон Японы шинэ Үндсэн хуулиар Японы эзэн хааны эрхийг хязгаарлан парламентын эрх хэмжээг өргөтгөснөөс гадна хамгийн гол нь шинэ үндсэн хуулийн 9-р зүйлээр Япон улс арми байгуулах, цэрэг аж үйлдвэрийн чадамжаа сэргээхийг хориглон, олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хүч хэрэглэхээс үүрд татгалзах тухай заасан байдаг билээ.

Гэтэл Японы эрх баригчид нь АНУ-ын дэмжлэгтэйгээр 1951 онд Сан-Францискийн салангид “Энх тайвны гэрээ” гэгчийг байгуулж, түүний үндсэн дээр 50-иад оны эхэн үеэс эхлэн Японы милитаризмыг дахин сэргээх ажилд шилжиж орсон юм. 1954 он гэхэд Япон улс “өөрийгөө хамгаалах хүч” гэдэг нэрийн дор халхавчлан жинхэнэ армийг бий болгон байгуулах ажлаа дуусчээ. Одоо Японы зэвсэгт хүчин 240 мянган хүнтэй болсноос гадна армия зэвсэглэсэн байдал, байлдааны ажиллагааг явуулах бололцоо, түүний зэвсгийн галын хүч чадал зэрэг нь эзэн хааны урьдах армиас даруй хэдэн арав дахин давуу байдалтай болоод байна. Өрнөдийн цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Японы арми нь “цэвэр батлан хамгаалах зорилт”-

---

<sup>14</sup> “Үнэн” 1984, х. 24.

ын хэмжээнээс нь аль хэдийнээ үсрэн гарч, бусад орныг довтлон эзлэх хүч чадалтай болсныг<sup>15</sup> ний нуугүй тэмдэглэхийн зэрэгцээ хөрөнгөтөн орнуудын армийн дотор Японы арми нь 5-6 дугаар байранд орж байна.

Ялангуяа сүүлийн 20 жилд Японд цэрэг дайны хэнээрхэл улам гаарч, цэргийн төсөв зардал 10 дахин өсөн нэмэгдэв. Хэрэв 1965 онд Япон Улсын цэргийн зардал 301 сая 400 мянган иен байсан бол 1985 онд энэ төсөв зардал нь 3 триллион 14 сая иенд хүрэв.<sup>16</sup>

Япон улс нь АНУ, Өмнөд Солонгосын тоглоомын дэглэмтэй цэрэг-улс төрийн холбоо байгуулж, өөрийн орны нутаг дэвсгэрт Америкийн пуужин-цөмийн зэвсгийг байрлуулахыг зөвшөөрч, Ази Номхон далайн районд АНУ-ын цэргийн төсөв зардлыг хэмнэн өөр зэвсэглэл (тухайлан “Оддын дайны” программ)-д зориулах бүрийн цэргийн зардлыг байнга нэмэгдүүлэн, улс орноо цэрэгжүүлж байна. Одоо Япон улсын цэргийн аж үйлдвэр нь “Өөрийгөө батлан хамгаалах хүч”-ийг залуурт пуужин, орчин үеийн танк, сөнөөгч бөмбөгдөгч онгоц, тэнгисийн мина тээгч хамгийн шилдэг хөлөг онгоц, шумбагч онгоц, хамгийн орчин үеийн электрон тоног төхөөрөмжөөр хангаж байна. Цэргийн зарим төрлийн зэвсэг үйлдвэрлэн гаргах талаар Япон улс нь хөрөнгөтөн ертөнц дотроо зөвхөн АНУ-ын дараагаар орж байна. Японы цэрэг зэвсгийн зардалд үндэсний орлогын 1 хувиас хэтрэхгүй хөрөнгө мөнгө зарцуулж байх тухай Японы парламентын 1976 оны шийдвэрийг ч АНУ-ын дайнчдын шаардлага, даралт шахалтаар Японы засгийн газар зөрчиж, түүнийг 3%-д хүртэл нэмэгдүүлэх гэж байна. Энэ бүхнээс үзэхэд Японы эрх баригчид шинэ үндсэн хуулийн 9-р зүйл, парламентын тогтоосон хязгаарлал зэргийг дур мэдэн зөрчиж, улс орноо цэрэгжүүлэх ажлыг хүчтэй болгон Ази болон дэлхий дахины улс түмний энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлсэн хүч болж байна.

Үүнтэй холбогдуулан нөхөр Ж.Батмөнх саяхан хэлэхдээ, “Японд милитаризм сэргэж, түүний цэргийн хүч чадал, шинжлэх ухаан-техникийн потенциалыг АНУ цэрэг стратегийн сонирхолдоо ашиглаж байгаад Азийн улс түмний сэтгэл ноцтой түгшиж байна”<sup>17</sup> гэсэн билээ.

Иймээс сүүлийн үед ЗХУ болон манай улс социалист хамтын нөхөрлөлийн бусад орны хамт Ази, Номхон далайн сав газрын байдлыг хэвийн болгоход чиглэсэн хэд хэдэн тодорхой санаачилга дэвшүүллээ. Энэ санаачилгын дотор ялангуяа ЗХУ 1985 оны 8-р сарын 6-ны (Америк Японы Хиросима Нагасаки хоёр хотыг атомын бөмбөгөөр бөмбөгдсөний 40 жилийн ойн) өдрөөс эхлэн цөмийн зэвсгийн аливаа туршилтыг дангаараа зогсоосон тухай үүргийг дэлхийн дахины өмнө аваад хэрэгжүүлж байгаа нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсооход туйлын чухал ач холбогдол бүхий арга хэмжээ болж байгааг дэлхийн олон орон, ард түмэн сайшаан дэмжиж, АНУ-ыг ЗХУ-ын жишээгээр ажиллахыг зүй ёсоор шаардаж байна.

Эдүгээ дэлхийн 2-р дайны түүх зүйн судлал олон улсын тавцанд социалист, капиталист хоёр үзэл суртлын хурц ширүүн тэмцлийн талбар болж байна. Ах дүү социалист орнууд, ялангуяа ЗХУ-д дэлхийн 2-р дайны түүхийг марксист-ленинист сургаал, шинжлэх ухааны арга барил, түүхийн үнэн бодит баримт материалд тулгуурлан судалсан олон боть ном, ЗХУ-ын Эх орны аугаа их дайны нэрт жанжнуу-

<sup>15</sup> “Проблемы Дальнего Востока” М., 1985. № 2, с 33.

<sup>16</sup> Мөн тэнд. 34-р тал

<sup>17</sup> “Үнэн” 1985. VIII.30

дын дурдатгал, эмхэтгэл өгүүллүүдийг хэвлэж, нийтийн хүртээл болгохдоо өнгөрсөн дайны түүхэн сургамжаар ажилчин анги, хөдөлмөрчид, нэн түрүүн залуу үеийг хүмүүжүүлэн, орчин үед болон ирээдүйд дэлхий дахиныг хэзээ ч дэлхийн 2-р дайны үеийнх шигээр үл барам түүнээс илүү гай гамшигт хүргэхгүй байлгахын төлөө сонор сэрэмжээ дээшлүүлэн, цуцалтгүй тэмцэхэд өргөн олон түмний бүх хүч чадлыг дайчилж байна.

Гэтэл империалист үзэл суртлынхан, мөн жанжлах үзэлтнүүд түүхийн үнэн бодит байдлыг завхруулан өөрсдийн орчин үеийн улс төрийн бодлого, нийгмийн үзэл суртлын хэрэгцээний үүднээс түүхэн үнэнийг зориуд гуйвуулан бичих явдал газар авах боллоо. Тэд дэлхий 2-р дайн, түүний дотор Японы милитаризмын түрэмгийллийн түүхийг цагаатгахыг элдвээр оролдон, милитарист Японыг бутцохиход ЗХУ-ын гүйцэтгэсэн шийдвэрлэх ролийг аль болохоор бууруулсан мөн манай БНМАУ-ын оруулсан хувь нэмрийг үгүйсгэсэн олон тооны боть, ном хэвлэлийг гаргаж байна. Тухайлан дэлхийн 2-р дайны түүхийн асуудлаар АНУ, Англи, ХБНГУ, Японд өдий төдий боть номыг хэвлэн гаргаж байгаа ажээ. Үүнд: АНУ-д “АНУ-ын арми дэлхийн 2-р дайнд” хэмээх 85 боть ном, Японд “Аугаа их Дорнод Ази дахь дайны албан ёсны түүх” хэмээх 96 боть номыг хэвлэн гаргажээ. Мөн Англид “Дэлхийн 2-р дайны түүх” хэмээх 80 боть ном, ХБНГУ-д “Германы эзэнт улс ба дэлхийн 2-р дайн” гэсэн 10 боть номын эхний хэсгийг хэвлэжээ. Хөрөнгөтөн орнуудад дэлхийн 2-р дайны түүхээр нийтлэгдсэн эдгээр олон боть ном зохиолын ихэнх нь түүхэн үнэнийг мушгин гуйвуулж завхруулахад чиглэжээ.

Өнөө үед фашизм, милитаризм, хонзогнох үзэл дахин сэргэж, империалист харгис дайнч хүчнүүд урьд өмнө үзэгдээгүйгээр цэрэг зэвсгийг нэмэгдүүлэн, манай гаригийн амьдралыг нэгмөсөн сөнөөх аюул бүхий пуужин-цөмийн болон химийн зэрэг хөнөөлт зэвсгийн хойноос улайран хөөцөлдөж, дайны аюул занал улам ихсэж байгаа нь өнгөрсөн дайны түүхийг үнэн зөвөөр үнэлэн, улс түмнийг маш өндөр сонор сэрэмжтэй байж, ирээдүгээ итгэл төгс харж, бүх хүч чармайлтаа дайчлахыг зүй ёсоор шаардаж байна.

## ИСТОРИЧЕСКОЕ ЗНАЧЕНИЕ РАЗГРОМА ЯПОНСКОГО МИЛИТАРИЗМА И СОВРЕМЕННОСТЬ

### Резюме

Вслед за разгромом гитлеровской Германии вступление СССР в войну против милитаристской Японии 40 лет назад, т.е. в августе 1945 года по взятим на себя обязательствам Ялтийским и Потсдамским соглашениями явилось закономерным продолжением Великой Отечественной войны советского народа, неотъемлемой частью его героической борьбы против фашизма и милитаризма. Оно было продиктовано гуманными соображениями скорейшего завершения второй мировой войны и общими интересами установления мира на Дальнем Востоке и во всем мире.

Авторы статьи, приводя большие фактические материалы, отмечают, что милитаристская Япония заключив “антикоминтерновский пакт”, а затем “тройственный военный союз” с фашистской Германией и Италией в целях уничтожения социализма, подавления рево-

люционного движения народов и установления японского господства над Азией развязала вторую мировую войну и совершила грабительские военные походы против других стран.

Поэтому вступление СССР и МНР в войну против милитаристской Японии, как отмечают авторы, явилось справедливым делом, направленным на обеспечение свободы, независимости и безопасности своих стран, избавление народов оккупированных стран и территорий от японского ига. Оно полностью отвечало стремлениям и чаяниям свободолюбивых народов, целям и задачам объединенных наций, боровшихся против милитаризма и фашизма.

Разгром в весьма короткий срок Советской Армией совместно с Монгольской Народно-Революционной Армией опорной силы японского милитаризма – более миллионной отборной Квантунской армии в Маньчжурии привёл к безоговорочной капитуляции милитаристской Японии 2 сентября 1945 года. В связи с этим авторы статьи подчеркивают, что в победе над японским милитаризмом во второй мировой войне решающую роль сыграли Советский Союз и его вооружённые силы.

Всемирно-историческая победа Советского Союза и других свободолюбивых народов во второй мировой войне над фашизмом и милитаризмом коренным образом изменила соотношение сил на международной арене в пользу сил социализма и мира, демократии и национального освобождения. Образовалась мировая система социализма и её единое ядро-содружество социалистических государств стало ведущей силой в современном мире, идущей во главе социального прогресса человечества. Как никогда возросла роль международного коммунистического рабочего и национально-освободительного движений. В настоящее время, как пишут авторы статьи, в 95 странах мира действуют коммунистические и рабочие партии, которые объединяют в своих рядах более 80 млн коммунистов. Потерпела полный крах колониальная система империализма и со времени окончания II мировой войны более 100 стран Азии, Африки и Латинской Америки завоевали свою политическую независимость. Таким образом, в корне изменилась политическая карта мира.

Однако, силы империалистической реакции, прежде всего агрессивные милитаристские круги США, вопреки горьким урокам второй мировой войны, открыто провозглашая “крестовый поход” против социализма и освободительного движения народов, вынашивают захватнические планы мирового господства. Для этой цели они создали по всему миру огромное количество военных баз, астрономически увеличивают ежегодные военные ассигнования и оснащение своих армий еще более опасными видами вооружения, сколачивают агрессивные военно-политические союзы и проводят различного рода провокационные военные маневры.

В заключении статьи авторы резко притикуют и осуждают милитаризацию Японии вопреки 9-й статье Конституции страны под нажимом Пентагона, которая противоречит коренным интересам японского народа, делу мира и безопасности народов на Дальнем Востоке и в регионе Тихого океана. В связи с этим авторы статьи также критикуют идеологов империализма и милитаризма, которые ныне всячески пытаются оправдать поджигателей II мировой войны, в том числе и японских милитаристов, очернить миролюбивую внешнюю политику СССР, снизить его решающую роль в победе, отрицать вклад МНР в разгром японского милитаризма.